



Монголын Залуучуудын Нам Mongolian Youth Party

2004 оны 04 сар 15 өдөр

№ 61/27

Улаанбаатар хот

Бүгд хурлын шийдвэр


Намын ээлжит бус бүгд хурлаар УИХ-ын сонгуульд оролцох асуудлыг хэлэлцэн дараах шийдвэрийг гаргаж байна.

1. УИХ-ын сонгуулийн бүх тойрогт нэр дэвшүүлэн дангаараа оролцох шийдвэрийг баталсугай.
2. Сонгуулийн мөрийн хөтөлбөр, зохион байгуулалтын ажлын төслийг намын дүрмийн 3-2т заасны дагуу боловсруулж 04-р сарын 28ны дотор сонгуулийн штабт ирүүлэхийг Тамгын газар-т /дарга н. Золбаяр/ даалгасугай
3. Сонгуулийн ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулалт хийхийг зөвшөөрсүгэй.
4. УИХ-ын ээлжит сонгуульд оролцох хүсэлтийг холбогдох материалын хамт Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороонд хүргүүлэх асуудлыг намын Удирдах Зөвлөлд хариуцуулсугай.


Бүгд Хурлын Тэргүүлэгчид


Дарга:  Н.Зууннаст


Е/н/б дарга М.Мөнхнаран


Тамгын газрын дарга:  Х.Золбаяр

Гишүүд:

 Б.Буянбадрах

 Б.Хүрэлбаатар

 Ч.Энхамгалан

 С.Дэлгэрцогт



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

1998 оны 5 дугаар
сарын 11-ны өдөр

№ 02

Улаанбаатар
хот

Монгол Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын хуралдааныг шүүгч Б.Цогням даргалж, шүүгч Ж.Дашдорж, Д.Тунгалаг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Д.Нямдорж Монголын Залуучуудын намыг төлөөлж намын дарга И.Зуунаст, намын нарийн бичгийн дарга М.Мөнхнаран нарыг оролцуулан Дээд шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн хуралдаанаар Монголын Залуучуудын нам /МЗН/-ыг бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдөл материалыг хянаад ОЛСОН нь:

Монголын Залуучуудын нам бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдөлд:

Бидний хэсэг нөхөд 1997 оны 12 дугаар сараас "Монголын Залуучуудын нам"-ыг байгуулахаар зориглон 1997 оны 12 дугаар сарын 12-нд анхдугаар чуулган /иххурлыг/ зохион байгуулсан намын дүрэм, эрхэмлэх зүйлийг санал нэгтэй баталсан юм.

Манай нам "Эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, хөгжлийн дэвшлийг хангах, зан заншил уламжлал соёлоо дээдлэн хүндэтгэх, залуу үеийнхний хүсэл сонирхол бүх талын мэдлэг боловсрол, ажил мэргэжил, авъяас билгийг хөгжүүлэн дэмжих, ахмад үеэ хайрлан хүндэтгэж, тэднээс суралцах, өөртөө итгэх итгэл, нийгмийн идэвхийг дээшлүүлэх замаар залуу үеийнхний хэлхээ холбоос зузаатган бэхжүүлэх үзэл санаа бүхий чөлөөт ардчилсан шинжтэй улс төрийн байгууллага болох талаар бүхий л ажлаа чиглүүлж явуулах болно.

Манай нам хүн төвтэй хөгжлийн доторх залуучууд төвтэй хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахын төлөө манай нам өөрийн хүч боломжоо дайчлан ажиллахыг эрмэлзэнэ. Ингэхдээ Залуучуудыг нийгмийн хөдөлгөгч хүч хэмээн үздэг аль ч улс төрийн, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллахын төлөө байна. Иймд манай намыг Улсын бүртгэлд бүртгэж үйл ажиллагаа явуулах эрхийг олгох өгнө үү гэсэн байна.

ХЯНАВАЛ:

Монголын Залуучуудын намыг бүртгүүлэхээр гаргасан өргөдөл, түүнд хавсаргасан намын бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн тухай мэдээ 821 гишүүн бүртгэл зэрэг нь хуулийн шаардлага хангасан бөгөөд дүрэм, эрхэмлэх зүйл нь Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намуудын тухай хууль бусад хуульд нийцэж байх тул Монголын Залуучуудын намыг Улсын бүртгэлд бүртгэх үндэслэлтэй байна. Улс төрийн намуудын тухай Монгол Улсын хуулийн 6 дугаар зүйлд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монголын Залуучуудын намыг улсын бүртгэлд бүртгэж Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намуудын тухай Монгол улсын хууль болон бусад хуулийг дээдлэн сахиж ажиллахыг Монголын Залуучуудын намд мэдэгдсүгэй.

3. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл гомдлоо Монгол Улсын Дээд шүүхийн хуралдаанд гаргаж болохыг мэдэгдсүгэй.

ДАРГАЛАГЧ
ШҮҮГЧ



Б.ЦОГНЯМ
Ж.ДАШДОРЖ
Д.ТУНГАЛАГ